Нийтийн тээврийн газар

# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт
## / 2023 оны III сарын тайлан мэдээ /

2023 оны 04 дүгээр сарын 05 Улаанбаатар хот

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | 2023 оны III сарын хэрэгжилтийн үр дүнгийн тухай мэдээлэл | Хэрэгжилтийн үнэлгээ | | | | | 30 болон 0 үнэлгээтэй бол удааширсан шалтгаан | | | Хэрэгжилтийн явц | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | ХБ | Санхүүжилтээс | Зохион байгуулалтаас | Урт хугацаанд хэрэгжих | Бүрэн хэрэгжсэн | Тодорхой ахиц гарсан | Ажил огт хийгдээгүй |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | | | | | | | |
| Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-05-19 Дугаар 2021_146 | 2.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Үндэсний хөгжлийн газар (Х.Батжаргал) нарт даалгасугай. | Улсын төсвийн хөрөнгөөр 2023-2024 онд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийтийн тээврийн парк шинэчлэлтийн их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобус, цахилгаан хөдөлгүүртэй 160 автобус, дунд багтаамжийн 50 автобус нийт 810 автобус худалдан авахаар төлөвлөн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Тэнүүн огоо” ХХК-ийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001 тоот гэрээ байгуулж, урьдчилгаа санхүүжилт 30 хувийг шилжүүлэн, үйлдвэрийн үйл ажиллагаа эхлүүлээд байна. | | + | | | | | | | | + | |
| | 3.Энэ тогтоолын 1, 2-т заасан санхүүжилтийн эх үүсвэрийн хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын авто зам, замын өргөтгөл, шинэчлэл, зогсоол, уулзвар, нүхэн гарц, гүүрэн байгууламж, хурдны замын бүтээн байгуулалт, нийтийн тээврийн парк шинэчлэл зэрэг зам, тээвэр зохицуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тооцож төлөвлөхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шиамень голден драгон бус ХХК-тай 2022 онд байгуулсан гэрээний дагуу энэ оны 01-03 дугаар сард их багтаамжийн 224 автобусыг Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т гэрээний дагуу хүлээлгэн өгч, гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Моннис Моторс ХХК-аас сургуулийн хүүхдийн 50 автобусыг хүлээлцэж, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110 дугаар захирамжийн дагуу 9 | | + | | | | | | | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүүрэгт хуваарилан хүлээлгэн өгч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж гэрээг дүгнэн, санхүүжилтийг олгуулахаар нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлээд байна. | | | | | | | | | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | | | | | | |
| 2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14 | XII.4.16.Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Нийслэлийн нийтийн тээвэрт агаарын дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн хоёрдугаар шугамыг эцэслэн тохирч, төслийн хэрэгжилтийг хангахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт; | Бүгд Найрамдах Франц Улсын "Пома групп" болон "Эжис Рейл" компанийн хамтарсан түншлэл нь 2022 оны 11 дүгээр сард Дүүжин тээврийн 2 дугаар шугам буюу Наадамчдын өргөн чөлөөг Энхтайваны өргөн чөлөөтэй холбох "Нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбор-Хар хорин автобусны буудал" 4.2 км урттай чиглэлийг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх ажлын хүрээнд "Пома групп" болон "Эжис Рейл" компанийн хамтарсан түншлэл нь техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг туслан гүйцэтгэгчээр хийлгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын явц 80 хувьтай байгаа талаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр "Түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл"-өөс зохион байгуулсан уулзалтад мэдээлэл өгсөн. | | + | | | | | | | + | |
| 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 31 дүгээр тэмдэглэл 2022-05-31 Дугаар 2022_31 | XXIII.2.1."Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br>1."Нийтийн тээврийг шинэчлэх", "Тулгуурт гүүрэн байгууламж бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх төсөл" болон "Шинэ тойрог зам барих төсөл"-ийн ажлыг 2022 онд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт; | Тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэг төслийг "Шинэ бүтээн байгуулалт" ХХК хариуцаж байна. Нийтийн тээврийн газраас хамтран ажиллах , мэдээлэл солилцох талаарх саналаа 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/02/597 тоот албан бичгийг "Шинэ бүтээн байгуулалт" ХХК-д хүргүүлсэн.<br>Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хотын хөнгөн галт тэрэгний нэгдүгээр чиглэлийн трассын кадастрын зургийн цэг тэмдэг тавих, трассын дагуух инженерийн шугам сүлжээ бүхий байр зүйн зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт "Геодата" ХХК шалгарсан бөгөөд ажлын тайланг хүлээн авахаар ажиллаж байна.<br>Хөдлөх бүрэлдэхүүний вагон депо, удирдлагын төв болон засвар үйлчилгээний барилга, байгууламжийн зориулалтаар 110,06 га газар | | | + | | | | | + | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | буюу 35 нэгж талбарыг улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршлын координатыг НИТХ-ын 2022 оны 39 дүгээр тогтоолоор батлуулсан. | | | | | | | | | | | |
| | XXIII.2.3.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээнд "Нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийг хамруулах талаар холбогдох арга хэмжээ авч, 2022-2024 онд барьж байгуулахаар тооцож төлөвлөхийг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Франц улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр баригдах агаарын дүүжин тээврийн төслийн Франц улсын төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж буй ажлын хэсэгтэй нэгдсэн уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж, төслийн анхан шатны холбогдох мэдээллийг хүргүүлсэн.<br>Уг төслийн хоёрдугаар шугамыг эцэслэн тохирсон бөгөөд газрын асуудал бүрэн шийдвэрлэгдэж, төслийг эхлүүлэхээр нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | | + | | | | | | | | + | |
| | XXIII.2.4.Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн хүртээмж, үйлчилгээг сайжруулах зорилгоор нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд хийгдэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт. | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шиамень Голден Драгон Бус ХХК-ийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан НЗДТГ-03/01, 03-01/01, 03/02, 03-02/02 дугаар гэрээний дагуу 2023 оны 02 дугаар сард их багтаамжийн дизель хөдөлгүүртэй нийт 224 автобусыг "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-т тус тус хүлээлгэн өгөөд байна.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Тэнүүн-Огоо ХХК-ийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001 гэрээ байгуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх их болон дунд багтаамжийн 810 автобус худалдан авах гэрээний дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, урьдчилгаа санхүүжилтийг шийдвэрлүүлэн үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлээд байна. | | + | | | | | | | | + | |
| 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 | IX.1.2.Нийслэлийн авто замын зорчих хэсэгт нийтийн тээврийн тусгайлсан эгнээ бий болгох, автобусны богино эргэлтийн чиглэл нэвтрүүлэх санал боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны | Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны А/12 дугаар тушаалаар Ч:63 "Хан хиллс хотхон-Ривер гарден-Баянмонгол хороолол-МУБИС-Ард кино театр" чиглэлийг 2022 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн Ч:63А "Хан хилсс хотхон – Ривер гарден – МУБИС – Ард кино театр", Ч:63Б | + | | | | | | | | + | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дугаар 2022_47 | дарга Ж.Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | “Дүнжингарав худалдааны төв – Баян монгол хороолол – Төв номын сан” болгон богино эргэлтийг үйлчилгээнд нэвтрүүлсэн.<br>Хан-Уул дүүрэг, Буянт Ухаа-2 хороолол, Шинэ яармаг хорооллын иргэдийн зорчих эрэлтэд тулгуурлан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тус газрын даргын А/23 дугаар тушаалаар батлагдсан нийтийн тээврийн үйлчилгээний богино эргэлтийн Ч:75 "Архивын Ерөнхий газар-Сонсголон-5 шар" шинэ чиглэл нээсэн. Замын хөдөлгөөний түгжрэл, саатлын шалтгааны улмаас нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг багасгах, алслагдсан суурьшлын цэгүүдээс богино эргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор тус газрын даргын А/39 дүгээр тушаалаар, 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Ч:29А “Сэлбэ амралт-Сансар-Зүүн 4 зам”, Ч:29Б “Зүүн 4 зам-Сансар-Вокзал” чиглэлүүдийг үйлчилгээг эхлүүлсэн. Мөн 2023 оны А/40 дүгээр тушаалаар Хан-Уул дүүргийн 8, 9, 16, 21, 25 дугаар хороодын иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Ч:76 "Нисэх-ТЭЦ-4-3,4-р хороолол" чиглэлийг шинээр нээсэн. | | | | | | | | | | | |
| | IX.1.3.“Наадамчдын өргөн чөлөө”, эсхүл “Энхтайваны өргөн чөлөө”-ний авто замд нийтийн тээврийн хэрэгслийн “зорчих хэсгийн тусгайлсан эгнээ”-г барьж байгуулах төслийг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлд хамруулах санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл зураг төсөв, зөвлөх үйлчилгээний хүрээнд 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад 7 гудамж замаар 31.9 км нийтийн тээврийн тусгайлсан эгнээ байгуулах санхүүжилт батлагдаж Нийслэлийн замын хөгжлийн газар захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна. | | | + | | | | | + | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | IX.1.4."Car pooling service" буюу автомашин хуваалцах үйлчилгээний талаар судалж, нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | 2023 оны нэгдүгээр улирлын байдлаар хэрэгжсэн арга хэмжээ байхгүй болно. | | | | | | | | | | | + |
| | IX.1.16.Нийтийн тээврийн автобусны тоог нэмэгдүүлэх, автобусны терминал, бааз байгуулах ажлыг эрчимжүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд шинээр орж ирсэн 224 автобусыг үйлчилгээнд үе шаттайгаар оруулах ажлыг төлөвлөн зохион байгуулж байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл зураг төсөв, зөвлөх үйлчилгээний хүрээнд 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 9 дүгээрт Нийслэлийн нийтийн тээврийн 2 терминал байгуулах зураг боловсруулах ажлын санхүүжилт 1 тэрбум төгрөг батлагдсан. Дээрх ажлын хүрээнд зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах ажил хийгдэж байна.<br>Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Тэнүүн-Огоо ХХК-ийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001 гэрээ байгуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх их болон дунд багтаамжийн 810 автобус худалдан авах гэрээний дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, урьдчилгаа санхүүжилтийг шийдвэрлүүлэн үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.<br>Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо Морингийн даваанд нийтийн тээврийн автопаркийг барихаар төлөвлөж байна. Автопаркийг нийт 8 га газарт гадна авто зогсоолд 170 автобус, 2 гараашд 110 тээврийн хэрэгсэл байхаар тооцож, автозасвар, угаалга, гадна засварын байгууламж, агуулах, уурын зуух зэрэг байгууламж барихаар эдийн засгийн үндэслэлийг гаргасан. Автопаркийн зураг төсөл холбогдох төсвийг эцэслээд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар дээр бараа үйлчилгээний худалдан авах ажлыг зохион байгуулсан. | | + | | | | | | | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | IX.1.17.Нийтийн тээврийн салбарын удирдлага, зохион байгуулалт, менежментийг өөрчлөх, шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэлийн нийтийн тээврийн газрын даргын А/27 тушаалаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд түвшин тогтоох шалгалтыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 28-ны өдрүүдэд зохион байгууллаа. Шалгалтын ажлын хэсэгт төрийн болон төрийн бус нийт 7 байгууллагын 14 албан хаагч оролцож, нийтийн тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, стандартын үнэлгээ өгч ажиллалаа.<br>Нийтийн тээврийн салбарын удирдлага, зохион байгуулалт, менежментийг сайжруулах, сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулагддаг "Ажил гүйцэтгэх гэрээ"-г шинэчлэн боловсруулж, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагатай шинэчилсэн гэрээг байгууллаа. | | + | | | | | | | | + | |
| | IX.1.18.Авто замын түгжрэлийг бууруулахад чухал ач холбогдол бүхий томоохон гүүрэн байгууламжийг Улаанбаатар хотод барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг 2023 оны улсын төсвийн төсөлд тусгаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Чиг үүрэгт хамааралгүй ажил болно. | | | | | | | | | | | |
| | IX.1.19."Их тойруу" доторх 4 байршил, Улаанбаатар хот руу орох чиглэлийн 2 байршилд их багтаамжийн давхар зогсоол шинээр барьж, менежментийг сайжруулах ажлыг судалж, Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 9 дүгээрт Нийслэлийн нийтийн тээврийн 2 терминал байгуулах зураг боловсруулах ажлын санхүүжилт 1 тэрбум төгрөг батлагдсан. Дээрх ажлын хүрээнд зураг төсөл боловсруулах, ажлын даалгаврыг боловсруулах ажил хийгдэж байна. | | | + | | | | | | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49 | XII.6.Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт даалгав: 1.Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн парк шинэчлэлтийг хийж, чанар, хүртээмжийг эрс сайжруулах, үйлчилгээний стандартыг тогтоох, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг шинэчлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангах;<br>2.Нийтийн тээврийн удирдлага, зохион байгуулалт, тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, ажлын явц байдлыг Засгийн газарт танилцуулж ажиллах; | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Тэнүүн-Огоо ХХК-ийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001 тоот гэрээ байгуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх их болон дунд багтаамжийн 810 автобус худалдан авах гэрээний дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, урьдчилгаа санхүүжилтийг шийдвэрлүүлэн үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.<br>Нийтийн тээврийн салбарын удирдлага, зохион байгуулалт, менежментийг сайжруулах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулдаг “Ажил гүйцэтгэх гэрээ"-г шинэчлэн боловсруулж, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагатай шинэчилсэн гэрээг байгууллаа. | | + | | | | | | | | + | |

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНТБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ Г.ЦОЛМОНГЭРЭЛ